

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №1-р баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа.

Компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Компани 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Шинэ их Тэрбум Аудит ХХК-ийг хөндлөнгийн аудитын компаниар сонгон ажилласан.

Компани нь 2020 онд 643.1 сая төгрөгийн орлоготой, өмнөх оноос 5.9 хувиар өссөн, бөгөөд 213.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 26.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2020 онд коронавирусын цар тахлаас үүдэн хэд хэдэн удаагийн хөл хорио тавьсантай холбоотойгоор зээл олголт буурсан.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл:

Цалин -	134.5 сая төгрөг
Аудит, мэргэжлийн үйлчилгээ-	49.6 сая төгрөг
Түрээс-	16.5 сая төгрөг
Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал-	7.8 сая төгрөг
Маркетинг сурталчилгаа -	5.6 сая төгрөг
Зохицуулалтын хураамж-	3.9 сая төгрөг
Зээл барагдуулахтай холбоотой зардал-	2.0 сая төгрөг

2021 онд компанийн аудит, мэргэжлийн үйлчилгээний зардлыг бууруулах үүднээс хөндлөнгийн аудитын компанийг сольсон. Мөн татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг зөвхөн нэгдүгээр улиралд авахаар болсон.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант хугацаанд бусдаас авсан урт болон богино хугацааны өр төлбөргүй. 2.7 сая төгрөгийн татварын өглөгтэй байсан.

Үндсэн хөрөнгийн талаар:

2020 оны эцсийн байдлаар 22.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болно.

Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:

Компанийн 2020 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.2.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 441 тоот тогтоол, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланд тусгагдсан хуримтлагдсан ашгаас 339,326,259.30 /Гурван зуун гучин есөн сая гурван зуун хорин зургаан мянга хоёр зуун тавин есөн төгрөг гучин мөнгө/ төгрөгөөр нэмэгдүүлж, компанийн энгийн хувьцааны нэрлэсэн үнийг 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ болгон нэмэгдүүлсүгэй.
2. Компанийн дүрмийн сангийн тооцооллыг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.Чинзориг
Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
03-тоот тогтоолын Хавсралт №1



ДҮРМИЙН САНГИЙН ТООЦООЛОЛ

Тайлбар	Одоо	Шинэчилсэн
Дүрмийн сан	2,262,175,062	2,601,501,321.30
Хувьцааны тоо	1,131,087,531	1,131,087,531
Хувьцааны нэрлэсэн үнэ	2 төгрөг	2 төгрөг 30 мөнгө

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай

Монгол Улсын банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйл, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж авсугай.
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Бизнес төлөвлөгөөг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журмыг Хавсралт №2-оор баталсугай.
4. Итгэлцлийн үйлчилгээний нөхцөлийг Хавсралт №3-аар баталсугай.
5. Хөрөнгө итгэмжлэх гэрээний загварыг Хавсралт №4-өөр баталсугай.
6. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.Чинзориг
Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
05 тоот тогтоолын Хавсралт №1



Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	580,000	6,960,000
2	Цалин /гишүүд/	8	420,000	40,320,000
3	Цалин/ нарийн бичгийн дарга/	1	420,000	5,040,000
4	ТУЗ-н бичиг хэрэг			500,000
5	ТУЗ-ын томилолт			30,000,000
Нийт дүн				82,820,000

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:


1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ



 Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ХЭ-ийн ээлжит
 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
 06 тоот тогтоолын Хавсралт №1

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтүүд:

Харьцуулалтууд		
Шинэчилсэн	Хуучин	Тэмдэглэл
3.1.4 “Итгэлцлийн үйлчилгээ”		Нэмсэн
6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,601,501,321.30 /Хоёр тэрбум зургаан зуун нэг сая таван зуун нэг мянга гурван зуун хорин нэгэн төгрөг гучин мөнгө/ төгрөг байна.	6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,262,175,062 /Хоёр тэрбум хоёр зуун жаран хоёр сая нэг зуун далан таван мянга жаран хоёр/ төгрөг байна.	Шинэчилсэн
6.2.1 Компани нь нийт 3,003,866,050 ширхэг зарласан хувьцаатай. Үүнээс нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 /хоёр тэрбум/ ширхэг зарласан энгийн хувьцаатай, нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,003,866,050 ширхэг зарласан давуу эрхийн хувьцаатай байна.	6.2.1 Компани нь нийт 3,003,866,050 ширхэг зарласан хувьцаатай. Үүнээс нэг бүр нь 2 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 /хоёр тэрбум/ ширхэг зарласан энгийн хувьцаатай, нэг бүр нь 2 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,003,866,050 ширхэг зарласан давуу эрхийн хувьцаатай байна.	Шинэчилсэн
6.2.2 Компани нэг бүр нь 2.30 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,131,087,531 /Нэг тэрбум нэг зуун гучин нэгэн сая наян долоон мянга таван зуун гучин нэгэн/ ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.	6.2.2 Компани нэг бүр нь 2 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,131,087,531 /Нэг тэрбум нэг зуун гучин нэгэн сая наян долоон мянга таван зуун гучин нэгэн/ ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.	Шинэчилсэн
9.2.22 Түр томилогдсон гишүүн нь энэ дүрмийн 9.2.5-т заасан шаардлагыг хангасан байна.	9.2.22 Түр томилогдсон гишүүн нь энэ дүрмийн 7.25-т заасан шаардлагыг хангасан байна.	Зассан